



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны A/45 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулахыг Эцэг эхийн зөвлөл (С.Туул)-д даалгасугай.

2.Арга хэмжээнд шаардагдах 1,720,000 (нэг сая долоон зуун хорин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

